

1992 ОНЫ МАЛ ТООЛЛОГО

I. Малчдын тоо, тэдний соёл, ахуйн байдал

I.1. Малчдын тоо, бүрэлдэхүүн. Хөдөө аж ахуйн компани, хоршоо болон үйлдвэр, аж ахуйн нэгж, албан байгууллага, амины аж ахуйн салбарт 1992 оны жилийн эцсийн байдлаар нийт 143.4 мянган өрх бүхий 330.1 мянган малчид ажиллаж байна. Малчин өрхийн тоо өмнөх оныхос 24.7 хувь буюу 28.4 мянга, малчдын тоо 34.7 хувь буюу 85 мянгаар нэмэгдэв.

Хөдөө аж ахуйд өмч хувьчлагдсантай холбогdon өндөр настан болон хот, суурин түүний дүүргийн мал бүхий иргэдээс мал аж ахуйн үйлдвэрлэл амьдралынх нь эх сурвалж болж байгаа, мал сүргээ жилийн дөрвөн улиралд эрхэлж малладаг хүмүүсийг малчин өрх, малчдын тоонд хамруулахаар холбогдох яам, эрдэм шинжилгээний байгууллагын саналыг авсны үндсэн дээр тооллогын зааварт тусгасан болно.

Нийт малчдын 52.9 хувь нь 16-35 насны залуучууд байна.

Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

	1989	1990	1991	1992
Малчин өрх (мян)	69.0	74.7	115.0	143.4
Малчдын тоо (мян)	135.4	147.5	245.0	330.1
Насны бүрэлдэхүүн (хувиар)	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс: 16- 35 насны	51.0	55.7	56.5	52.9
36-аас тэтгэвэрт гараах хүртэл насны	45.0	40.3	31.2	29.4
Тэтгэврийн насны	4.0	4.0	12.3	17.7

Улсын хэмжээгээр 44.1 мянган ардын аж ахуйтан өрх байгаа нь 1991 оныхос 5.5 дахин нэмэгдэв. Нийт малчин өрхийн 30.8 хувийг ардын аж ахуйтан эзэлж, үүнээс Дорнод аймагт 70 хувь, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий аймагт 51-59 хувь, Дорноговь, Булган аймагт 1.9-5.4 хувь нь ардын аж ахуйтан байна. 1991 онд нэг малчинд дунджаар 104 толгой мал ногдож байсан бол 1992 онд 78 толгой мал ногдох боллоо.

I. 2. Малчдын соёл, ахуйн зарим үзүүлэлт. Цахилгаан гэрлээр хангагдсан малчин өрх 1991 онд 12.3 мянга байсан бол 1993 онд 15.5 мянга боллоо.

1992 онд нийт малчин өрхийн 10.8 хувь нь цахилгаан гэрэлтэй болсон нь өмнөх жилийн түвшинд байна. Дархан, Эрдэнэт, Улаанбаатар хотын малчин өрхийн 23.7

– 41.5 хувь, Сүхбаатар, Өвөрхангай, Дорнод, Дорноговь, Дундговь аймгийнх 15.6 – 18.0 хувь нь цахилгаан гэрэлтэй болсон байхад Завхан, Баян-Өлгий, Увс, Хөвсгөл аймагт энэ үзүүлэлт дөнгөж 2.8 – 6.6 хувьтай байна.

1991 онд малчин өрхийн 3.6 хувь нь телевизортэй байсан бол 1992 онд 4.8 хувь нь телевизортэй болов.

Малчдын нийт өрхийн 39.5 хувь гэрийн даавуу бүрээсгүй, 42.4 хувь нь брезентэн бүрээсгүй байгаа нь өмнөх оныхоос байдал улам мууджээ. Увс, Төв, Баян-Өлгий аймагт малчдын гэрийн 48.1 – 67.0 хувь нь даавуу болон брезентен бүрээсгүй байна. Харин 1992 онд малчин өрхийн 17.7 хувь буюу 25.4 мянган өрх эсгий хийсэн байна. Уламжлалт аргаар нийтдээ 194.2 мян.метр гар эсгий хийсэн нь өмнөх оныхоос 2.2 дахин нэмэгджээ. Дээрх хэмжээний эсгий хийхэд ойролцоо (нэг эсгий хийхэд 28 кг ноос орно гэвэл) тооцоогоор 1.1 мянган тонн хонины ноос зарцуулсан байна.

Радио хүлээн авагчгүй өрхийн тоо нэмэгдэж, хангамж нь буурав. Малчин өрхийн 27.6 хувь буюу 39.6 мянга нь радио хүлээн авагчгүй байгаагийн дотор Увс, Архангай, Ховд, Хөвсгөл аймагт гурван өрх тутмын нэг нь радио хүлээн авагчгүй байна.

Малчин өрхийн соёл, ахуйн хангамжийн зарим үзүүлэлт (мян.өрх)

	1989	1990	1991	1992	1992\1991 хувь	Малчин өрхийн тоонд эзлэх %	
						1991	1992
Цахилгаан гэрэлтэй	11.4	11.2	12.3	15.5	126.0	10.7	10.8
Телевизортэй			4.2	6.9	164.3	3.6	4.8
Богино долгион холбоотой өрх			20	30	150.0	0.02	0.02
Эсгий хийсэн			12.1	25.4	209.9	10.5	17.7
Гэрийн даавуу бүрээсгүй	10.6	15.1	41.4	56.6	136.7	36.0	39.5
Гэрийн брезентэн бүрээсгүй	19.3	22.2	46.4	60.7	130.8	40.4	42.4
Радио хүлээн авагчгүй	8.0	12.6	22.2	39.6	178.4	19.3	27.6
Хийсэн эсгий (мян.метр)			87.9	194.2	220.9		

I.3. Мал аж ахуйн мэргэжилтний хүрэлцээ хангамж. 1992 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд малын эмч 1661, мал зүйч 501 ажиллаж байгаа нь 1989 онтой зэрэгцүүлбэл мал зүйчийн тоо 2.4 дахин буурсан байна.

1989 онд улсын хэмжээгээр нэг мал зүйчид дунджаар 20.3 мян.мал ногдох байсан бол 1992 онд 51.3 мян.мал ногдох болов. Одоо Өмнөговь, Сүхбаатар, Өвөрхангай аймагт нэг мал зүйчид дунджаар 108 – 180 мян.толгой мал ногдох

байна. Өмнөговь аймагт 1989 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 53 мал зүйч ажиллаж байсан бол одоо ердөө 5 ажилладаг болсон байна.

Мал аж ахуйн мэргэжилтний тоо, хангамж (мян)

	1989	1991	1992	1992\1989%
Мал зүйч	1214	787	501	41.3
Малын эмч	1827	1599	1661	90.9
Нэг мал зүйчид ногдох малын тоо (мян.тол.)	20.3	32.4	51.3	252.7
Нэг малын эмчид ногдох малын тоо (мян.тол.)	13.5	16.0	15.5	114.8

Хувьчлагдсан мал. 1992 онд 86.4 мянян өрх хувьчлалаар 3.5 сая мал авсны дотор 1.8 сая нь хээлтэгч мал байна. Нийгмийн өмчид хамрагдаж байсан нийт малын 30.3 хувь, хээлтэгч малын 30.2 хувь нь нэмж хувьчлагджээ.

II. МАЛЫН ТОО

2.1. Нийт малын тоо. 1992 оны эцэст 25.7 сая мал тоологдсон нь 1991 оныхоос толгойн дүнгээр 166.2 өссөний дотор ямаа 352.9 мянгаар нэмэгдэж, хонь 64 мянгаар, тэмээ 60.8, үхэр 2.8, адuu 59.1 мянгаар цөөрөв. Бодод шилжүүлснээр малын тоо 119.7 мянгаар буурсан байна.

Малын тоо (мян.тол.)

	1991	1992	1992/1991	
			%	Зөрүү
Бодоор *	8905.0	8785.3	98.7	-119.7
Толгойн тоо	25527.9	25694.1	100.7	-166.2
Тэмээ	476.0	415.2	87.2	-60.8
Адуу	2259.3	2200.2	97.4	-59.1
Үхэр	2822.0	2819.2	99.9	-2.8
Хонь	14721.0	14657.0	99.6	-64.0
Ямаа	5249.6	5602.5	106.7	352.9

* Бодод шилжүүлэхдээ адuu, үхрийг нэг бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод гэж тооцлов.

Толгойн дүнгээр 10 аймаг, 4 хот малынхаа тоог 1991 оныхоос өсгөв. Сүхбаатар, Булган, Баянхонгор, Говь-Алтай аймаг, Улаанбаатар, Эрдэнэт хотын малын тоо өнгөрсөн оныхоос бодод шилжүүлснээр 6.7 – 19.1 мянга, толгойн дүнгээр 19.2 – 87.4 мянгаар нэмэгдсэн байна.

4 хот, Сүхбаатар, Булган аймаг тэмээнээс бусад төрөл дээр малаа өсгөв.

Сумдаас Булганы Баяннуур, Баянхонгорын Баянцагаан, Галуут, Завханы Завханмандал, Сүхбаатарын Мөнххаан зэрэг 9 аймгийн 16 сум малаа таван төрөл бүр дээр нь өсгөжээ.

Малын тоо бодод шилжүүлснээр 14, толгойн дүнгээр 8 аймагт урьд оныхос буурсны дотор Баян-Өлгий, Дорнод, Хөвсгөл, Хэнтий, Өмнөговь аймаг 27.7 – 126.4 мянгаар хорогдуулжээ. Сумдын дотроос малынхаа тоог урьд оныхос 23.0 – 29.7 хувь буюу 9.0 – 33.4 мянгаар хорогдуулсан Ховдын Ховд, Сэлэнгийн Хүдэр, Хөвсгөлийн Рэнчинлхүмбэ, Дорнодын Халхгол, Чулуунхороот сумд сүүлийн байранд орж байна.

1954 онд манай улс 895 мянган тэмээтэй байсан бол жилээс жилд цөөрсөөр одоо тоо толгой нь 2.2 дахин хорогдоод байна. Зөвхөн сүүлийн хоёр жил дараалан 61 – 62 мянгаар хорогдсон нь улсдаа хамгийн олон тэмээтэй Өмнөговь аймгийн 1992 онд байгаа тэмээнээс илүү зарлага гарчээ.

Тэмээний тоо толгойг хэрхэн буурч байгааг дараах
хүснэгтээс харж болно.

	Дундаж тоо (маян.тол)	Өмнөх онуудаас буурсан хэмжээ (маян.тол)
1951 – 1960 онд	870.0	-
1961 – 1970 онд	755.0	115.0
1971 – 1980 онд	611.0	144.0
1981 – 1990 онд	562.0	49.0
1991 – 1992 онд	445.0	117.0

1992 онд улсын хэмжээгээр 44.7 мян.ботго бойжуулж, 21.4 мян.тэмээ зүй бусаар хорогдож, 84.1 мянган тэмээг хүнсэнд зарлагадсан байна. 100 эхээс 35 ботго бойжуулсан нь 1986 – 1990 оны дунджаас 5 ботгоор цөөрчээ. Тэмээг хүнсэнд урьд өмнө нь үзэгдээгүй олон тоогоор хэрэглэх болсон нь түүний тоо толгойг эрс буурах үндсэн шалтгаан болсон байна.

1992 онд 113.7 мянган тэмээ хувьчлагдсныг харгалзан үзвэл амины салбарын тэмээ энэ хэмжээгээр өсөх үндэстэй байсан. Гэтэл хөдөө аж ахуйн компанийн тэмээ 128.2 мянгаар цөөрч, амины аж ахуйн тэмээ 67.4 мянгаар нэмэгдсэн байна. Үүнээс үзэхэд хувьчлалаар аминд өгсөн тэмээнээс наад зах нь 46 мянган тэмээ хүнсэнд хэрэглэгджээ.

1992 онд тэмээтэй нийт сумдын дөрөвний гурав буюу 207 сум тэмээнийхээ тоог хорогдуулсан байна.

Тэмээн сүргийн нөхөн үйлдвэрлэлийн байдлыг үзүүлбэл :

	1986-1990 оны дундаж	1991	1992	1992\1986- 1990 хувь
Тэмээний тоо	549.2	476.0	415.2	75.6
Ингэний тоо	149.5	127.3	112.2	75.1
Сүрэгт хээлтэгчийн эзлэх хувь	27.2	26.7	27.0	-
Бойжуулсан ботго	60.3	52.9	44.7	74.1
100 эхээс бойжуулсан ботго	40	38	35	87.5
Зүй бус хорогдол	25.8	20.8	21.4	82.9
Оны эхний тэмээнд эзлэх хувь	4.7	3.9	4.5	-
Хүнсэнд хэрэглэсэн тэмээний тоо	38.9	93.6	84.1	216.2
Үүнээс: улсын бэлтгэлд өгсөн	8.8	7.7	3.3	37.5

Ноднин жил “ Тэмээн сүргийг хамгаалах, ёсгөж үржүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай “ Засгийн газрын 93 дугаар тогтоол гарсан билээ. Гэтэл манай хамгийн олон тэмээтэй Өмнөговь, Дорнговь, Дундговь, Говь-Алтай, Баянхонгор, Увс, Ховд аймаг тэмээнийхээ тоог 3.9-13.7 мянгаар хорогдуулав. Эдгээр аймгийн дүнгээр тэмээний тоо 45.2 мянгаар цөөрсөн нь улсын хэмжээний тэмээний тоо толгойн бууралтын 74.3 хувь болж байна.

Нийт адууний тоо 59.1 мянгаар хорогдсоны дотор Өвөрхангай, Увс, Архангай, Дундговь, Баян-Өлгий аймагт 7.1 – 15.3 мянган толгойгоор буурчээ.

Улсад нийт малаар болон хонины тоогоор Завхан, адуугаар Төв, үхрээр Хөвсгөл, ямаагаар Баянхонгор, тэмээгээр Өмнөговь аймаг тэргүүн байранд хэвээр байна.Хамгийн олон малтай сумын тоонд Дундговь аймгийн Эрдэнэдалай сум нийт малын тоогоор (252.3 мян) болон хонь (146.7 мян), адуугаар (26.9 мян), Өмнөговийн Ханбогд сум тэмээгээр (14.9 мян), Архангайн Хангай сум үхрээр (29.5 мян), Өвөрхангайн Богд сум ямаагаар (184.2 мян) тус тус орж байна.

Хувийн (амины) малын тоо. 1992 онд улсын хэмжээгээр аминдаа малтай 301.5 мянган өрх байгаа нь өмнөх оныхоос 12.6 мянгаар мянгаар нэмэгдсэн байна.

Сүүлийн хоёр жилд нийгмийн малын хувьчилснаар амины малын тоо 1991 онд нийт малын 54.9, 1992 онд 70.4 хувийг эзлэх болов. Энэ үзүүлэлт 1990 онд 31.9 хувь байв. Амины малын тоо ноднингийнхоос 4.1 саяаар нэмэгдэн 18.1 саяд хүрч, нийгмийн мал 33.9 хувь буюу 3.9 саяаар буурсан байна. Үхэр, адуу, ямааны 76.3 – 79.4, хонины 65.4, тэмээний 61.1, бодод шилжүүлсэн малын 73.7 хувь нь амны аж ахуйд ногдох болжээ. Дорнодоос бусад бүх аймаг, хотод амины малын тоо урьд оныхоос 4.2 – 58.6 хувиар өссөний дотор Өвөрхангай, Хөвсгөл аймагт 477.0 – 683.4 мянга, Говь-Алтай, Архангай аймагт 301.2 – 389.8 мянга, Дундговь, Завхан, Ховд, Баянхонгор, Төв аймагт 213.5 – 294.5 мянга, Хэнтий, Увс, Сүхбаатар, Өмгөновь аймагт 136 – 190 мянга, бусад аймаг, хотод 9.6 – 72.6 мянгаар нэмэгдэв.

Амины малын нийт өсөлтийн 85.4 хувийг хувьчлалаар нийгмийн малаас аминд шилжиж ирсэн өсөлтөөр, үлдэх хэсгийг сүргийн нөхөн үйлдвэрлэлийн өсөлтөөр хангасан байна.

Амины малын 54.2 хувь нь ХАА-н компани, хоршооны гишүүдэд, 26.8 хувь нь ардын аж ахуйтанд, 19 хувь нь ХЭАА, бусад иргэдэд ногдож байна.

Аминд байгаа малын бүтцийг авч үзвэл хонь 53.0 хувь, ямаа 23.6, үхэр 12.4, адуу 9.6, тэмээ 1.4 хувийг эзлэж байна.

1992 онд тоологдсон амины мал (мян)

Өрхийн тоо	Малын тоо бүгд		Үүнээс				
			Тэмээ	адуу	үхэр	Хонь	Цмаа
ХАА-н компани, хоршооны гишүүд	127.2	9792.2	139.1	979.2	1132.0	5097.4	2444.8
Ардын аж ахуйтан	44.1	4847.3	101.1	455.4	518.1	2691.7	1081.0
ХЭАА, бусад иргэд	130.2	3438.1	13.5	292.9	586.7	1798.6	746.4
Алдуул мал	-	3.2	0.0	0.5	0.6	1.4	0.7
Дүн	301.5	18081.1	253.7	1728.0	2237.4	9589.1	4272.9

1992 онд аминдаа малтай нийт өрхөд 10 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин 1991 оныхоос 3 пунктээр, 11-30 малтайнх 1.8, 31 – 50 малтайнх 0.9, 51 – 100 малтайнх 0.1 пунктаар багасч, 101 – 200 толгой малтай өрхийн хувийн жин 3.2, 201-ээс дээш малтайнх 2.6 пунктаар нэмэгдсэний дотор 501- 1000 малтай өрх 308, 1001 –ээс дээш малтай өрх 7 байна.

Иргэдийн амины малын бүлэглэлт (тоо-мян)

	Малтай өрхийн тоо		Дунд эзлэх хувь		Малын тоо (мян.тол)	
	1991	1992	1991	1992	1991	1992
10 хүртэл малтай	65.0	58.9	22.5	19.5	402.2	381.9
11-30 малтай	71.6	69.2	24.8	23.0	1396.2	1345.9
31-50 малтай	50.9	50.2	17.6	16.7	2043.9	2006.5
51-100 малтай	63.8	66.3	22.1	22.0	4467.2	4684.0
101-200 малтай	31.9	42.8	11.0	14.2	4233.0	5754.8
201-500 малтай	5.7	13.7	2.0	4.5	1421.7	3674.6
501-1000 малтай	5.7	0.4	2.0	0.1	1421.7	222.8
1001-ээс дээш	-	7 өрх	-	-	-	7.4
ДҮН	288.9	301.5	100.0	100.0	13964.2	18078.0

Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл, Архангай, Дундговь аймагт дунджаар нэг өрхөд ногдох амины малын тоо 1991 оныхоос 5.3 – 8.4 бодоор нэмэгдэв.

Улсын дунджаар малтай нэг өрхөд 22 бод, 60 толгой мал ногдож байхад Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Дорноговь аймагт 28-33 бод, Дундговь, Өмнөговь, Говь-Алтай, Ховд аймагт 83-106 толгой мал ногдож байна.

Хээлтэгч мал. 1992 оны эцэст 11463.1 мянян хээлтэгч мал тоологдсон нь урьд оныхоос 177 мянгаар буурчээ. Эм ямаанаас бусад хээлтэгч малын тоо урьд оныхоос буурсан байна.

Хээлтэгч малын тоо (мян.тол)

	1989	1990	1991	1992	1992\1991	
					хувь	зөрүү
Ингэ	151.1	140.9	127.3	112.2	88.1	-15.1
Гүү	554.6	563.5	575.6	566.0	98.3	-9.6
Үнээ	1084.2	1127.2	1064.0	1032.2	97.0	-31.8
Эм хонь	7384.7	7786.1	7407.2	7098.8	95.8	-308.4
Эм ямаа	2245.7	2425.7	2466.3	2653.9	107.6	187.6
ДҮН	11420.3	12043.4	11640.4	11463.1	98.5	-177.3

Баянхонгор, Говь-Алтай, Булган, Сүхбаатар, Ховд, Завхан, Дундговиос бусад аймагт хээлтэгч малын тоо урьд оныхоос буурсан байна.

Бүх хээлтэгч малын 64.9 хувь нь амины, 35.1 хувь нь нийгмийн аж ахуйд байгаагийн дотор ингэний 57.7, гүүний 76.8, үнээний 73.3, эм хонины 60.0, эм ямааны 72.7 хувь амины аж ахуйд байна.

Нийгмийн хээлтэгч мал бүх аймагт буурч, улсын дүнгээр 2048.8 мянгаар цөөрөв.

1992 онд 2099.8 мян.хээлтэгч шинээр нас дэвшиж нэмэгдсэн нь нийт хээлтэгчийн 18.3 хувь болж байна.

Төл бойжилт. 1992 онд гарсан төлийн 93.7 хувь буюу 8.7 сая төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 875 мянгаар цөөрсөн байна. Бойжсон нийт төлөөс 141.1 мянгыг улс, орон нутгын бэлтгэлд, 155.7 мянгыг аж ахуйн дотоод хэрэгцээнд, 15.6 мянгыг каракуль арьсанд нядалжээ. Улс орон нутгын бэлтгэлд хэрэглэсэн төлийн тоо 1991 оныхоос 264.7 мянгаар буурав.

Төл бойжилт (мян.тол)

Бүгд		Ү Ү Н Э С					Зөрүү
		ботго	унага	тугал	хурга	ишиг	
Гарсан	9319.6	47.7	329.3	749.0	6137.1	2056.5	-932.4
Бойжсон	8736.3	44.7	314.9	725.2	5726.8	1924.7	-875.5
Хорогдсон	583.3	3.0	14.4	23.8	410.3	131.8	-56.9
Бойжилтын Хувь	93.7	93.7	95.6	96.0	93.3	93.6	-

1992 онд 100 эхээс бойжуулсан төл өмнөх таван жилийн дунджаас 6-аар, 1991 оныхоос 5-аар бага байна.

100 эхээс бойжуулсан төл

	1986-1990 оны дундаж	1991	1992	Үүнээс :	
				амь	нийгэм
Ботго	40	38	35	49	28
Унага	62	61	55	68	32
Тугал	69	68	68	86	42
Хурга	86	83	77	93	66
Ишиг	80	82	78	88	65
Бүгд	81	80	75	89	62

100 хээлтэгчээс Баян-Өлгий, Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор, Ховд аймаг 81-86 төл бойжуулсан байхад, Хэнтий, Өмнөговь, Дорнод, Сэлэнгэ аймаг 61-65 төл бойжуулжээ.

Амины 100эх малаас бойжуулсан төл нийгмийнхээс 27-оор, үүний дотор ботго 21, хурга 27, унага 36, тугал 44, ишиг 23-аар илүү байна.

Том малын зүй бус хорогдол. 1992 оны эхний малын 3.4 хувь буюу 871.0 мянган том мал зүй бусаар хорогдсон нь 1991 оныхоос 107.2 мянгаар бага, 1986-1990 оны дунджаас 119.1 мянгаар багассан байна.

Том малын зүй бус хорогдол (мян.тол)

	1986-1990оны дундаж	1990	1991	1992
Тэмээ	25.8	31.2	20.8	21.4
Адуу	64.3	70.4	72.7	80.6
Үхэр	79.5	73.1	104.1	118.1
Хонь	438.7	369.4	624.1	516.6
Ямаа	143.6	129.1	156.0	134.3
Бүгд	751.9	673.2	978.2	871.0

Оны эхний малд зүй бус хорогдолын эзлэх хувь

	1986-1990оны дундаж	1990	1991	1992
Тэмээ	4.7	5.6	3.9	4.5
Адуу	3.1	3.2	3.2	3.6
Үхэр	3.1	2.7	3.7	4.2
Хонь	3.3	2.6	4.1	3.5
Ямаа	3.2	2.6	3.0	2.6
Бүгд	3.3	2.7	3.8	3.4

Хэнтий, Увс, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл, Завхан аймагт оны эхний малын 4.4-5.8 хувь буюу нийтдээ 25.6-91.8 мянган том мал зүй бусаар хорогдсон нь улсын хэмжээний нийт хорогдлын 45.4 хувийг эзлэж байна.

Том малын зүй бус хорогдолын 37.8 хувь буюу 329.0 мянга нь өвчинеэр, 21.0 хувь буюу 183.3 мянга нь гэнэтийн аюулаар хорогдов. Хорогдсон нийт малын 61.0 хувь нь нийгмийн мал байна. Амины малын 2.4 хувь хорогдсон байхад нийгмийн малын 4.6 хувь хорогджээ.

Малын хээл хаялт, сувайралт. 1992 оны эхний хээлтэгч малын 15.1 хувь буюу 1758.7 мянга нь хээл хаясан, сувайрсан шалтгаанаар төл өгөөгүй нь 1991 оныхоос 13.3 хувь буюу 206.4 мянгаар их байна. Сүүлийн жилүүдэд хээл хаяж, сувайрсан шалтгаанаар төл өгөөгүй малын тоо улам нэмэгдсээр байна.

1992 оны байдлаар улсын дүнгээр долоон хээлтэгч дутамын нэгээс төл авч чадсангүй. Ялангуяа гүүний гуравны нэг, үнээний дөрөвний нэг нь сувайрч, хээл хаяснаас зөвхөн 1992 онд 200 мянган унага, 260 мянган тугал нэмж хүлээн авах боломж алдлаа.

Өмнөговь аймаг оны эхний хээлтэгч малын 26 хувиас, Дархан хот, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймаг 20.3 – 23.1 хувиас дээрх шалтгаанаар төл авч чадсангүй. Өмнөговь аймагт гүүний 55 хувь, үнээний 42.7 хувь, эм хонь, ямааны 23 – 27 хувь нь сувайрч, хээл хаясан нь урьд өмнө нь гарч байгаагүй их хэмжээ юм. Тус аймаг 100 эхээс 42 унага, 50 тугал, 66 ишиг бойжуулсан нь улсын дунджаас 12 – 18 төлөөр доогуур байна. Дархан хот 100 эхээс 49 хурга, Дорнот, Хэнтий аймаг 61 – 64 хурга бойжуулсан нь улсын дунджаас 13 – 28 толгойгоор бага байна.

Төл өгөөгүй хээлтэгч малын тоо (мян.тол)

	Төл өгөөгүй хээлтэгч мал бүгд				үүнээс сувайрсан			1992\1986-1990 хувь
	1986-1990 дундаж	1991	1992	1992\1986-90 хувь	1986-1990 дундаж	1991	1992	
Ингэ	12.5	16.8	16.9	135.2	9.9	12.9	13.4	135.4
Гүү	180.1	192.0	209.1	116.1	158.1	146.8	158.1	100.0
Үнээ	278.1	303.4	264.6	95.1	240.8	248.0	210.1	87.3
Эм хонь	446.3	751.5	900.3	201.7	276.0	527.1	638.1	231.2
Эм ямаа	275.6	288.6	367.8	133.5	139.7	179.3	216.1	154.7
ДҮН	1192.7	1552.3	1758.7	147.5	824.5	1114.2	1235.9	149.9

Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь

	Бүгд			үүнээс сувайрсан			
	1986-1990 онд	1991	1992	1986-1990	1991	1992	
Ингэ	8.2	11.9	13.3	6.5	9.2	10.5	
Гүү	34.4	34.1	36.3	30.2	26.1	27.5	
Үнээ	26.9	26.9	24.9	23.3	22.0	19.8	
Эм хонь	6.2	9.7	12.2	3.8	6.8	8.6	
Эм ямаа	12.5	11.9	14.9	6.3	7.4	8.8	
ДҮН	10.8	12.9	15.1	7.4	9.3	10.6	

Хээлтээгч, хээлтүүлэгчийн тохироо. Малын хээл хаялт, сувайралт ихэссэн нь мал нийлүүлгийн ажилд үргжлийн бодлого, мэргэжилтний нөлөө, хяналт супарсан, үйлдвэрлэлд ажиллаж байгаа мал зүйчийн тоо эрс цөөрсөн, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан зэрэг шалтгаантай холбоотой. Мал аж ахуйд ажиллаж байгаа мал зүйчийн тоо 1990 онд 956 байсан бол 1991 онд 787, 1992 онд 501 болжээ. 1990 онд нэг мал зүйчид дунджаар улсын хэмжээгээр 27 мянган мал ногдож байсан бол 1992 онд 51 мянган мал ногдох боллоо. Малын сувайралт үлэмжхэн гарсан Өмнөговь аймагт дөнгөж 5 мал зүйч ажиллаж, нэг мал зүйчид дунджаар 180 мянган мал ногдох болжээ. Үргжлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25 – 30 хээлтэгч ногдох ёстой байхад одоо 49 хээлтэгч ногдож, хуц, ухна хүрэлцээгүй болсон байна. Ялангуяа амины аж ахуйд хуц, ухна нэн дутагдалтай болж, нэг хээлтүүлэгчид 88 эм хонь, 72 эм ямаа ногдох болсон нь нормоос 2.5 – 3 дахин хэтэрчээ.

Хээлтүүлэгч малын тоо (мян.тол)

	Бүгд				үүнээс шинээр тавьсан			
	1990	1991	1992	1992\1991	1990	1991	1992	1992\1991
Буур	4.1	4.0	4.0	100.0	66.0	14.0	49	350.0
Азрага	70.5	76.1	81.3	106.8	0.9	0.6	0.6	106.9
Бух	59.5	61.7	60.4	97.9	2.5	1.3	0.9	69.2
Хуц	242.9	199.4	143.8	72.1	20.9	3.6	1.9	52.8
Ухна	73.6	65.0	54.5	83.8	0.5	1.4	0.5	35.7
ДҮН	450.6	406.2	344.0	84.7	31.9	6.9	3.9	56.5

Нэг хээлтүүлэгчид ногдох
хээлтэгч малын тоо

	Үржлийн норм	1990	1991	1992
Ингэ	20-25	34	32	28
Гүү	12-15	8	8	7
Үнээ	35-45	22	17	17
Эм хонь	25-30	32	37	49
Эм ямаа	25-30	33	38	49

1990 онд нийт 20.9 мянган хурган хуц, 7.5 мянган ухна ишиг нэмж тавж байсан бол 1992 онд 1.9 мянган хурган хуц, 0.5 мянган ухна ишиг тавьсан байна.

Өвөрхангай, Архангай, Дорноговь аймагт хуц, ухна, Төв аймаг, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хотод хуц, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь аймагт ухна ихээхэн дутагдалтай болжээ.

Манай тэмээний үндсэн бүс нутаг болох Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говь-Алтай, Ховд аймагт буур хүрэлцээгүй болсон байна.

Мал тооллогын дүнгээс гарсан судалгааг үндэслэн энэ жил бог малын хээлтүүлэгчийг нөхөн тавиулах ажлыг орон нутагт хэрэгжүүлж, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог хангуулахын зэрэгцээ мал хээлтүүлгийн ажлын зохион байгуулалтад дорвитой өөрчлөлт гарган, мэргэжилтний удирдлага, хяналтыг хүчтэй болгох шаардлагатай байна.

Малын нийт хорогдол. 1992 онд төл, том малын хорогдол, хээл хаясан, сувайрсан мал 3213.0 мянгад хүрсэн нь 1991 оныхоос 1.3 хувь буюу 42.2 мянгаар ихссэн байна. Малын нийт хорогдол 1991 оныхоос Хэнтий, Баян-Өлгий, Төв аймагт 81.4 – 120.0 мянга, Говь-Алтай, Дорнод, Хөвсгөл, Архангай, Сүхбаатар аймагт 8.8 – 20.9 мянгаар буурч, бусад аймагт нэмэгдсэний дотор Дундговь, Завхан, Увс, Өмнөговь, Баянхонгор аймагт 5.5 – 76.0 мянгаар ихсэв.

Малын хэрэглээний зарлага. Малын нийт зарлага (төл, том малын зүй бус хорогдол ороогүй) 7683.5 мянга, үүнээс том малын хэрэглээний зарлага оны эхний малын оны эхний малын 27.2 хувь буюу 6939.8 мянгад хүрсний дотор улс, орон нутгийн бэлтгэлд 8.6 хувь буюу 4758.5 мянган мал зарцуулжээ. Аж ахуйн дотоодод, хүнсэнд хэрэглэсэн малын тоо өмнөх жилийнхээс 17.8 хувиар нэмэгдсэн байна.

Том малын хэрэглээний зарлага. (мян.тол)

	1986-1990 оны дундаж	1991	1992	1992\1991	
				хувь	зөрүү
Хэрэглээний нийт зарлага	7559.8	8930.4	7683.5	86.4	-1246.9
Үүнээс : Том малын	6736.4	7863.6	6939.8	88.3	-923.8
-Улсын бэлтгэлд	3445.6	3097.1	1774.4	57.3	-1322.7
-Орон нутгын бэлтгэлд	664.7	727.1	406.9	56.0	-320.2
-Аж хауйн дотоод болон бусад	2626.1	4039.4	4758.5	117.8	719.1

Сүхбаатар, Булган, Дорноговь, Говь-Алтай, Завхан аймагт оны эхний малынхаа 14.6 – 16.6 хувийг аж ахуйн дотоод хэрэгцээнд зарцуулсан байхад Баян-Өлгий, Архангай, Сэлэнгэ аймаг 21.7 – 29.9 хувийг зарцуулжээ.

1992 онд улсын төвлөрсөн хэрэгцээнд бэлтгэх мал, махны даалгавар урьдчилсан байдлаар 5.6 хувиар биелэгдэж, 71.4 мянган тонноор тасарч байна. Энэ тасалдлын дийлэнх нь Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Увс, Төв, Ховд, Завхан аймагт ногдож байна. Экспортод 6.5 тонн амьдын жин бүхий мал гаргасан нь урьд жилийнхээс 3 дахин багасчээ.

Улсын бэлтгэлд тушаах малаас тооллогын өмнө орон нутагт нядлаагүй үлдсэн малыг хэрхэн шийдвэрлэсэн талаар одоо аймаг, сумдад дүнг тооцож гаргах шаардлагатай байна.

Малын нийт хэрэглээний
зарлага. (мян.тол)

	1986- 1990 оны дундаж	1991	1992
Бүгд	7559.8	8930.5	7683.5
Тэмээ	38.9	93.6	84.1
Адуу	201.7	273.8	293.4
Үхэр	544.3	684.6	609.9
Хонь	5311.3	6174.6	5258.6
Ямаа	1463.6	1703.9	1437.5

Оны эхний малд эзлэх хувь

	1986- 1990 оны дундаж	1991	1992
Бүгд	31.8	34.5	30.1
Тэмээ	7.1	17.4	17.7
Адуу	9.5	12.1	13.0
Үхэр	20.8	24.0	21.6
Хонь	38.4	40.9	35.7
Ямаа	31.3	33.2	27.4

Сүргийн бүтэц. Нийт сүргийн 35.6 хувь нь төл, өсвөр насны, 44.6 хувь нь хээлтэгч, 18.4 хувь нь ажлын болон бэлтгэлийн насны эр, 1.3 хувь нь хээлтүүлэгч мал байна.

Сүргийн бүтэц (хувиар)

	Төл, өсвөр насны		Ажлын ба эр сувай		Хээлтэгч		Хээлтүүлэгч		Бүгд	Нийт малын	
	1991	1992	1991	1992	1991	1992	1991	1992		1991	1992
ДҮН	38.2	35.6	14.6	18.4	45.6	44.6	1.6	1.3	100.0	100.0	100.0
Тэмээ	34.3	32.5	38.1	39.5	26.7	27.0	0.8	1.0	100.0	1.9	1.6
Адуу	36.3	34.5	34.8	36.1	25.5	25.7	3.4	3.7	100.0	8.8	8.6
Үхэр	49.5	48.0	10.6	13.3	37.7	36.6	2.2	2.1	100.0	11.0	11.0
Хонь	37.1	34.7	11.2	15.9	50.3	48.4	1.4	1.0	100.0	57.7	57.0
Ямаа	36.1	32.5	15.6	19.1	47.0	47.4	1.2	1.0	100.0	20.6	21.8

Эх мал, бойжуулсан төлийн тоо буурсан нь сүрэгт эзлэх хувийн жинд нөлөөлөв. Амины мал аж ахуй өсөхийн хэрээр сүргийн бүтцэд эр сувай малын хувийн жин нэмэгдэж, хээлтүүлэгч малын хувийн жин буурсан өөрчлөлт гарчээ.

Нийт сүрэгт хээлтэгч малын эзлэх хувийн жин 44.6 болж, урьд оныхоос 1.0 пунктээр буурсны дотор үнээ 1.1, эм хонь 1.9-ээр буурч, эм ямаа, ингэ, гүүний хувийн жин 0.2-0.4 пунктээр нэмэгдэв. Амины болон нийгмийн аж ахуйн сүргийн бүтэц нэлээд ялгаатай байна.

Нийгэм, амны малын сүргийн бүтэц (хувиар)

	хувийн			нийгмийн		
	1990	1991	1992	1990	1991	1992
Төл, өсвөр насны	38.4	41.7	37.8	39.0	33.8	30.4
Ажлын ба эр сувай	20.2	17.6	19.9	9.5	11.1	14.8
Хээлтэгч	40.3	39.8	41.2	49.5	52.7	52.0
Хээлтүүлэгч	1.1	0.9	1.0	2.0	2.4	2.0
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

1992 оны эцэст бэлтгэлийн насны 3772.3 мянган эр мал тоологдсон нь өмнөх оныхоос 999.0 нэмэгдсэний дотор эр хонь 674.0 мянга, ямаа 250.3 мянга, үхэр 74.7 мянгаар өсчээ.

Амины аж ахуйн сүргийн бүтцэд бүх төрөл дээр төл, өсвөр насны мал, бэлтгэлийн насны эр малын эзлэх хувийн жин нийгмийн малынхаас харьцангуй илүү байна.

Ажлын мал. 1992 онд ажил эдэлгээний 126.6 мян.ат, 608 мян.морь, 62.8 мян.шар байгаа нь өмнөх оныхоос ат 6.8 мянга, морь 0.3 мянгаар буурч, шар 21.1 мянгаар нэмэгджээ. Улсын хэмжээгээр атны 94.9 хувь, морины 76.5, шарны 16.8 хувийг ердийн хөсөгт ашиглаж байна.

II.2. Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 1992 оны эцэст цэвэр үүлдрийн 408.3 мянга, эрлийз 757.5 мянга, нутгийн шилдэг омгийн 839.1 мянган мал тоологдсон нь 1991 оныхоос цэвэр үүлдрийн мал 45.4 мянга, нутгийн шилдэг омгийн мал 55.8 мянга, эрлийз мал 180.7 мянгаар цөөрсөн байна.

Цэвэр үүлдрийн ухэр 12.4 мянга, хонь 32.2, ямаа 0.8 мянгаар хорогдсоны дотор Сэлэнгэ, Төв, Архангай аймаг, Улаанбаатар хотод үхэр 1.3 - 2.3, Сэлэнгэ, Баянхонгор, Ховд, Хэнтий, Төв, Булган аймаг, Чойр, Дархан, Улаанбаатар хотод хонь 1.4 – 15.2 –оор буурчээ.

1992 онд тоологдсон нийт үхрийн 6.2 хувь, хонины 5.2, ямааны 4.1 хувь нь цэвэр, эрлийз мал эзлэж байна. Нийт цэвэр эрлийз малын 62.6 хувь нь хөдөө аж ахуйн компани, хоршоо, улсын үйлдвэрийн газарт, 33.8 хувь нь амины аж ахуйд байна.

1992 оны эцэст цэвэр үүлдрийн болон эрлийз 627.5 мянган хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 128.1 мянгаар цөөрчээ. Цэвэр үүлдрийн болон эрлийз малын сүрэгт үнээ 48.2, эм ямаа 52.6, эм хонь 55.5 хувийг эзлэж байна.

Нутгийн шилдэг омгийн үхэр 18.2 мянга, хонь 784.1 ямаа 36.7 мянга тоологдсон нь 1991 оныхоос үхэр 1.4 мянга, хонь 65.1 мянгаар буурч, ямаа 10.7 мянгаар өслөө. Хээцийн хүрэн, Галбын.govийн улаан, Говь-Алтайн хос зодорт 2.1 тэмээ тоологдов.

Өмч хувьчлалаар амины аж ахуйд очсон олон тооны цэвэр үүлдэр эрлийз шилдэг омгийн мал зохих үүлдэр, омгийн малын дансандаа орж тусгагдахгүй байна. Энэ байдалд хөдөө орон нутагт малыг үүлдэр, омгоор нь ялгаж салгадаг мэргэжлийн боловсон хүчин \ мал зүйч \ дутагдалтай болсон нь ихээхэн нөлөөлөх боллоо.

III. Малын хашаа, уст цэг

III. Малын хашаа, худаг. 1992 оны эцэст улсын хэмжээгээр 27.7 сая толгой малын багтаамжтай 74.4 мянган хашаа тоологдсон нь ноднин жилийнхээс хашааны тоо 6.4 мянгаар нэмэгдэж, багтаамж нь 522.5 мянган толгойгоор буурчээ. Энэ нь өвч хувьчлалтай холбогдон олон хашааг буулгаж багтаамжийг нь багасгаж барьсан, зарим нь өөр зориулалттай болсонтой холбоотой. Малын төрөлжсөн сууриуд задарч ихэнх хашаа бог мал, үхрийн зориулалттай болжээ.

Богийн болон үхрийн 27.3 сая толгой малын багтаамжтай 72409 хашаа байгаагийн 2.0 хувь нь дулаан байр, 16.0 хувь нь дулаалгатай хашаа, 64.2 хувь нь саравчтай хашаа, 17.4 хувь нь саравчгүй хашаа байна. Эдгээр хашааны 62.1 хувь нь өвөлжөөнд байгаа бөгөөд 66.9 хувь нь хувь нь хувиараа эрхлэх аж ахуй, хувийн, 29.3 хувь нь хөдөө аж ахуйн компани, хоршоо, улсын үйлдвэрийн газрын харьяалалд байна.

1992 онд 989.4 мянган толгой малын багтаамжтай 4993 хашаа шинээр ашиглалтанд оруулжээ.

Ховд, Хэнтий, Увс, Баян-Өлгий, Төв, Дундговь аймагт хашааны багтаамж ноднин жилийнхээс 142.0-423.3 мянган малынхаар буурчээ.

Улсын хэмжээгээр 6 сая төгрөгийн үнэтэй 553 хашаа ашиглагдахгүй байгаагийн ихэнх нь Сүхбаатар, Дорнод, Өмнөговь, Говь-Алтай, Ховд аймгуудад байна.

Үхэр бог малын дүнгээр 1.2 ээлжийн, тэмээний 47.3 хувь, адууны 1.6 хувь нь нэг ээлжийн хашаагаар хангагдсан байна. Малын хашааны хангамж 1989 оноос эхлэн жил тутам буурах боллоо. Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймагт хашааны хангамж ихээхэн доогуур байна.

Малын хашааны тоо, багтаамж, бүтэц

	1990	1991	1992	1992\1991 хувь
Нийт хашааны тоо \ мян \	66.2	68.0	74.4	109.4
Багтаамж \ сая тол \	30.7	28.3	27.7	97.9
Богмал, үхрийн хашааны хангамж \хувь\	131.1	122.2	118.3	96.8
Хашааны багтаамжид эзлэх хувь	100.0	100.0	100.0	
-дулаан байр	1.5	2.1	2.1	
-дулаалгатай хашаа	20.9	19.4	16.4	
-саравчтай хашаа	63.2	63.6	64.2	
-саравчгүй хашаа	14.4	14.9	17.3	

Уст цэг. 1992 оны эцэст улсын хэмжээгээр 36.3 мянган худаг тоологдоноы 823 нь шинээр ашиглалтанд оржээ.

Нийт худгын тоо 1991 оныхоос 1.3 мянгаар, үүний дотор өрөмдмөл 347, богино яндант 377, бетон хашлагат худаг 784-өөр тус тус буурсан байна.

Худгийн тоо Сэлэнгээс бусад бүх аймагт 1991 оныхоос буурчээ.

1992 онд 126.4 сая төгрөгийн үнэтэй 2997 худаг ашиглагдахгүй байгаа нь ноднингийнхоос 50.9 хувиар их байна. Ашиглагдахгүй байгаа худгийн ихэнхийг Сүхбаатар, Дорнод,Өвөрхангай, Хөвсгөл, Өмнөговь, Архангай аймгууд эзлэж байна.

Улсын хэмжээгээр 1992 онд 37.5 мянган м.куб багтаамжтай 2915 мал услах усан сан тоологдсон нь ноднин жилийнхээс 646-аар буурсан байна.

37.4 мянган га талбай услах хүчин чадалтай 135 услалтын систем байгаагаас 26.8 сая төгрөгийн үнэтэй 6.3 мянган га талбай услах чадалтай систем ашиглагдахгүй байна.

Уст цэгийн тоо (мян.ш)

	1990	1991	1992	1992\1991 хувь
Худаг бүгд	41.6	37.6	36.3	96.5
Үүнээс: Өрөмдмөл	7.5	6.6	6.2	93.9
Богино яндант	7.6	7.2	6.8	94.4
Бетон хашлагат	9.5	8.5	7.7	90.6
Энгийн уурхайн	17.0	15.3	15.6	102.0
Мал услах сан	4.2	3.6	2.9	80.6

III.2. Малын тэжээлийн үйлдвэрлэлт

Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж. 1992 онд улсын хэмжээгээр 405.7 мянган тонн тэжээлийн нэгжтэй тэнцэх хэмжээний тэжээл үйлдвэрлэсэн нь 1991 оныхоос 156.4 мян.тонн, 1986-1990 оны дунджаас 593.7 мянган тонн буюу бараг 2.5 дахин бага байна.

Завхан, Өмнөговь аймаг, Улаанбаатар, Эрдэнэт хотоос бусад аймаг, хот тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ өнгөрсөн оныхоос буурчээ.

Үйлдвэрлэсэн тэжээлийг нэр төрлөөр нь авч үзвэл олон наст ургамал, бэлтгэсэн даршинаас бусад бүх төрөл, тухайлбал сүрэл, нэг наст ургамал, гар тэжээл, багсармал тэжээл, бэлтгэсэн өвс, эрдэс тэжээлийн хэмжээ өмнөх оныхоос 11.0-62.1 хувиар багассан байна.

1992 оны байдлаар хонин толгойд шилжүүлсэн нэг мал, амьтдад тэжээлийн нэгжээр 7.5 кг тэжээл ногдож байгаа нь 1986-1990 оны дунджаас 10.9 кг-аар буюу 2.5 дахин 1991 оныхоос 2.8 кг-аар буурсан бөгөөд энэ нь цаг зуурын бэрхшээл тохиолдсон үед нийт малыг 3.7 хоног л тэжээх нөөц юм.

1992 онд улсын хэмжээгээр 668.8 мянган тонн байгалийн хадлан бэлтгэсэн нь өнгөрсөн оныхоос 209.8 мянган тонноор буюу 23.9 хувиар багасч, урьд жилүүдэд бэлтгэж байснаас \ 1986-1990 оны дунджаас \ бараг 2 дахин буурав.

Бэлтгэсэн өвсний хэмжээг өнгөрсөн оныхтой харьцуулахад зөвхөн Архангай, Өмнөговь аймаг, Дархан, Эрдэнэт хотод нэмэгджээ.

Улсын фондод 77.5 мян.тонн өвс бэлтгэж , даалгавар 56.9 хувиар тасрав. Улсын фондод өвс бэлтгэх даалгаварыг нэг чаймаг хот биелүүлсэнгүй.

Тэжээлийн хэмжээг нэр төрлөөр үзүүлбэл : (мян.т)

	1990	1991	1992	1992\1991 хувь
Байгалийн хадлан үүнээс	866.4	878.6	668.8	76.1
Улсын фондын өвс	155.1	157.6	77.5	49.2
Сүрэл	58.3	54.6	31.9	58.4
Нэг наст өвс	201.2	65.9	25.0	37.9
Олон наст өвс	25.6	8.2	8.3	101.2
Гар тэжээл (тэж.нэгж)	12.0	10.1	6.6	65.3
Багсармал тэжээл	57.5	23.6	21.0	89.0
Бэлтгэсэн дарш	254.1	91.1	128.2	140.7
Эрдэс тэжээл	42.4	15.5	12.9	83.2
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд(тэж.нэгж)	-	564.4	403.7	-

Тэжээлийн бүтцийг авч үзвэл шүүст болон бүдүүн тэжээлийн хэмжээ 1991 оныхоос нэмэгдэж, хүчит тэжээлийн хэмжээ буурлаа.

Үйлдвэрлэс тэжээлийн бүтэц, (хувиар)

	1990	1991	1992
Бүгд	100.0	100.0	100.0
хүчит	19.4	15.2	11.5
шүүст	8.8	5.3	7.1
бүдүүн	71.8	77.6	81.4
Бусад	-	1.9	-

1990 оноос эхлэн тэжээл үйлдвэрлэлт эрс буурсан бөгөөд өнгөрсөн жилийн хувьд ч гэсэн ямар нэгэн ахиц гарсангүй. Энэ нь малын тэжээлийн хангамжинд зохисгүй нөлөөлж, мал сүргийг цаг агаарын бэрхшээлийг гарз хохирол багатай давахад хүндрэл учруулж болзошгүй байдал сүүлийн жилүүдэд давтагдсаар байна.

Малын ихэнх нь амины аж ахуйд ногдох болсонтой холбогдон малчин өрх бүр тэжээлийн нөөцийг бий болгоход өөрсдийн идэвх санаачлагад тулгуурлах төдийгүй тэднийг бага оврийн техник, багаж хэрэгсэлтэй болгох нь чухал байна.

Тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх талаар орон нутагт зохион байгуулж байгаа ажил хангалтгүй байгаагаас хямд өртөгтэй тэжээлийн нөөц болох сүрэл, байгалийн хадланг бэлтгэх бололцоог ихээхэн дутуу ашиглаж байна.

IV. Тэжээвэр амьтад.

1992 оны эцест 48.6 мянган гахай, 184.0 мянган шувуу, туулай 164, үнэг 1001, булга 6005 тоологдон нь өнгөрсөн оныхоос гахайн тоо 34.7 мянга, шувууны тоо 39.3 мянга, туулай 1.9 мянгаар буурчээ.

Хувиараа эрхлэх аж ахуй, ард иргэдийн шувууний тоо 1991 оныхоос гахайн тоо 2.9 мянгаар нэмэгдсэн байна.

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөж, үржүүлдэг өрх, аж ахуйн тоо

	1989	1990	1991	1992	1992\1991
Гахай (мян.тол)	192.1	134.7	83.3	48.6	58.3
Шувуу (мян.тол)	370.0	326.2	223.3	184.0	82.4
Цаа буга	1405	1171	1336	1427	106.8
Илжиг, луус	1067	1018	791	935	118.2
Зөгий (бүл)	5012	4768	4567	1473	32.3
Туулай	12046	7179	2047	164	8.0
Үнэг	1271	1251	1209	1001	82.8
Булга	9973	9691	7513	6005	79.9
Минж	1610	1080	654	181	27.7
Гахайтай өрхийн тоо (мян)	22.3	15.7	12.1	7.6	62.8
Шувуутай өрхийн тоо	1.7	1.3	1.3	1.6	123.1

Гахай өсгөж үржүүлдэг АА, байгууллагын тоо	1299	845	482	225	46.7
Шувуу өсгөж үржүүлдэг АА, байгууллагын тоо	207	150	56	37	66.1

Бүх аймаг, хотод гахайн тоо, Сэлэнгэ, Увс аймаг, Дархан хотоос бусад аймаг, хотод шувууны тоо хорогдсон байна. Гахайн зүй бусын хорогдлын гуравны нэг нь Сэлэнгэ аймагт ногдож байна.

1992 онд аминдаа гахайтай өрх 7.6 мянга, шувуутай өрх 1.6 мянга болсон нь өнгөрсөн оныхоос гахайтай өрх 4.5 мянгаар цөөрч, шувуутай өрх 226-аар нэмэгдсэн байна. Одоо нийт гахайны 84.1 хувь, шувууний 11.0 хувь нь амины аж ахуйд байна. Гахай, шувуу өсгөж үржүүлдэг аж ахуй, албан байгууллагын тоо сүүлийн жилүүдэд эрс цөөрлөө.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ГАЗРЫН ДАРГА.....Б.ЦЭНД-АЮУШ
1993 – 02 - 10